

# Мөнгөний Систем

Үнээнүүд өөрсдийн засгийн газраа байгуулаад зогсолгүй өөрсдийн мөнгөний системийг бүтээхээр шийджээ. Өөрсдийн гэсэн хачин аргаараа мөнгөн тэмдэгт зохиох төлөвлөгөөтэй байгаа бөгөөд зоосны хэмжээнүүд нь ямар байвал тохиромжтой болохыг сонирхож байгаа аж. Уламжлал ёсоор 1т, 5т, 10т, 20т, 25т, 50т, 100-тын зооснууд байдаг бөгөөд 2тын зооснуудыг ч гүйлгээнд хэрэглэдэг.

Үнээнүүд янз бүрийн мөнгөн тэмдэгтийн системийг ашиглан өгөгдсөн мөнгийг хэдэн аргаар задалж болохыг мэдэхийг хүсчээ. Жижээ нь {1, 2, 5, 10, ...} мөнгөн тэмдэгтийн системийг ашиглан 18 нэгж мөнгийг хэрхэн задалах вэ?  $18 \times 1$ ,  $9 \times 2$ ,  $8 \times 2 + 2 \times 1$ ,  $3 \times 5 + 2 + 1$ , болон өөр олон аргаар задлаж болно.

Өгсөн мөнгөн тэмдэгтийн системийг ашиглан өгсөн мөнгийг хэдэн янзаар задалж болохыг олох програм бич. Нийлбэр дүн нь C,C++ хэлэнд signed long, Free Pascal-д Int64 төрөлд багтана.

**Програмын нэр: money**

**Оролтын формат**

Мөнгөн тэмдэгтийн систем дахь мөнгөний тоо  $V$  ( $1 \leq V \leq 25$ ).

Задлах мөнгөн дүн  $N$  ( $1 \leq N \leq 10,000$ ).

1-р мөр: 2 бүхэл тоо,  $V$  болон  $N$ .

2-р мөр: Зоосны хэмжээг илэрхийлэх  $V$  ширхэг бүхэл тоо.

**Жишээ оролт (файл money.in)**

3 10

1 2 5

**Оролтын формат**

$N$  мөнгийг  $V$  зооснуудаар хэдэн янзаар задалж болохыг илэрхийлэх нэг ширхэг бүхэл тоо.

**Жишээ гаралт (файл money.out)**

10

Орчуулсан Б.Даваабаяр